

ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

9-Р САРЫН 14, 2020

Эдийн засгийн судалгааны алба

Шинэ ургацын хүнсний ногоо гарснаар үнийн түвшин буурав. 2020 оны 8-р сарын байдлаар инфляцийн улсын ерөнхий индекс 2.1 хувь, Улаанбаатар хотод 1.7 хувь буюу 2016 оноос хойш хамгийн доод түвшиндээ хүрлээ. Улсын нийт үнийн түвшний өсөлт саарахад голчлон тээврийн бүлгийн барааны үнийн 6 хувийн бууралт нөлөөлсөн бол нийслэл хотод өсөлт саарахад хүнсний ногооны 20.4 хувийн бууралт нөлөөлжээ.

Ам.доллар өснө гэх иргэдийн хүлээлт буурахгүй байгаа холбоотой валютын хадгаламж жилийн 59 хувиар өссөн байна. 2020 оны 8-р сард мөнгөний нийлүүлэлт 4.5 хувиар өссөн ба нийт хадгаламжийн 15 хувийн өсөлт голлон нөлөөлөв.

Цар тахалтай холбоотойгоор татварын орлого буурч, халамжийн бодлогын нөлөөгөөр улсын нэгдсэн төсвийн алдагдал 2.7 их наядад хүрлээ. 2020 оны 8-р сарын байдлаар улсын төсвийн зардал 32 хувиар нэмэгдэж төсвийн орлого 17 хувиар буурсан байна. ЗГ-ийн урсгал шилжүүлгүүд буюу нийгмийн халамжийн мөнгө зэрэг шилжүүлэг нэмэгдэж, орлого талаас нийгмийн даатгалын орлого, бусад татварын орлого буурав. Ийнхүү цаашид улсын төсвийн алдагдал нэмэгдэх хандлагатай байна.


Алтны экспорт 233 хувь өссөнөөр гадаад худалдааны нийт тэнцэл 1 тэрбум ам долларын ашигтай гарлаа. Эсрэгээрээ нүүрсний экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 45 хувиар харин зэс 24 хувиар буурсан нь ийнхүү экспортын орлого буурахад нөлөөлөв. Харин ипмортын хувьд өмнөх оны мөн үеэс 15 хувиар буурчээ. Уул уурхайн салбар буурч байгаа нь шатахуун болон үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнд хүчтэй нөлөөлж байна.

Гадаад худалдаа ашигтай гарснаар төлбөрийн тэнцлийн алдагдал буурч байна. Эхний 7 сарын байдлаар төлбөрийн тэнцлийн алдагдал -344 сая ам долларын алдагдалтай гарав. Өмнөх улирлын 1 тэрбум ам долларын алдагдлаас ийнхүү буурсан нь гадаадын шууд хөрөнгө оруулалт өмнөх сараас 400 сая ам доллараар нэмэгдсэнтэй холбоотой байна.

Монгол банкны Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 1 нэгжээр буулган 8 хувь болголоо. Эдийн засгийн агшилт хүлээлтээс илүү хүчтэй байгаа тул идэвхжлийг дэмжих үүднээс ийнхүү бодлогын хүүг бууруулсныг Монголбанкнаас зарлав. Мөн 2020 оны эцсээр эдийн засаг 2.6 хувиар агшина гэж Монголбанк таамаглажээ.


ЭЗ Агент	Үзүүлэлт	Нэгж	2019.Q2	2019.Q4	2020.Q2	YoY /2020/
Бодит сектор	Бодит ДНБ өсөлт	%	7.2%	5.1%	-9.7%	-18.9 p.p
	Уул уурхайн ДНБ	%	13.3%	0.4%	-29.4%	-42.7 p.p
	Ажилгүйдлийн түвшин	%	10.1%	8.1%	6.6%	-4 p.p
	Ажилтай иргэд	Мянган хүн	1,293	1,188	1,269	-2.0%
			2019.08	2019.12	2020.08	YoY /2020/
	Инфляци	%	8.9%	5.2%	2.1%	-6.8 p.p
Мөнгөний бодлого	M2, үүнээс:	Их наяд ₮	20.5	20.8	21.4	4.5%
	Вал.хадгаламж	Их наяд ₮	2.9	3.5	4.7	59%
	Төг.хадгаламж	Их наяд ₮	10.9	11.1	11.2	4%
	Бодлогын хүү	%	11%	11%	8%	-3 p.p
	(MNT/USD)	₮	2,672	2,727	2,853	6.8%
Сангийн бодлого	Төсвийн орлого	Их наяд ₮	6.0	10.8	5.7	-17%
	Төсвийн зардал	Их наяд ₮	5.5	11.5	8.4	-32%
	Төсвийн тэнцэл	Их наяд ₮	0.55	-0.6	-2.7	
Гадаад сектор	Экспорт	Тэр ₮	5.4	7.1	4.5	-17%
	Импорт	Тэр ₮	4.1	6.1	3.5	-15%
	Гадаад худалд. тэнцэл	Тэр ₮	1.3	1.4	1.0	-23%
	Төлб.тэнцэл /2020.07/	Сая \$	39	453	-344	
	ГШХО /2020.07/	Сая \$	1,359	2,316	1,006	-26%
	ГВАН /2020.07/	Сая \$	3,689	4,349	3,621	-2%

Эдийн засгийн өсөлт




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Улсын төсвийн тэнцэл




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Мөнгөний нийлүүлэлт




Инфляци

— Улсын инфляци — Улаанбаатар хотын инфляци




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Гадаад худалдааны тэнцэл




Эх сурвалж: Үндэсний статистик хороо

Төлбөрийн тэнцэл




Гадаадын шууд хөрөнгө оруулалт

- Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Хуримтлуулсан, Сая ам.доллар/
- Гадаадын шууд хөрөнгө оруулалт /Тухайн сарын, Сая ам.доллар/




Гадаад валютын нөөц

■ Гадаад валютын нөөц ●●● Poly. (Гадаад валютын нөөц)




Эх сурвалж: Монголбанк

Ам.долларын ханш



Хүү



Эдийн засгийн судалгааны алба:

Шинжээч
Г.Батзориг
Имэйл: Batzorig_g@golomtbank.com

Шинжээч
Э.Батхорлоо
Имэйл: Batkhorloo@golomtbank.com

Эх сурвалж
1212.mn
mongolbank.mn
Голомт банкны дотоод эх сурвалж

Голомт банкны эдийн засгийн судалгааны алба нь макро эдийн засгийн судалгаа болон таамаглалуудыг дотоод ажилчид, харилцагчид болон олон нийтэд хүргэн ажилладаг. Тус тайланд 2020 оны 7, 8-р сарын тоон мэдээлэл болон зарим тохиолдолд 2-р улирлын тоон мэдээллийг ашигласан болно. Энэхүү судалгаа нь зөвхөн банкны дотоод хэрэгцээнд зориулсан бөгөөд Голомт банкны үзэл баримтлалыг илэрхийлээгүй болно.

*Улаанбаатар хот
2020 оны 9-р сар*